

ДЭД ДАРГА  
ХУРАНДАА

БАТЛАВ

Ц. ГАНЗОРИГ

2020 оны 8 дугаар сарын 27-ны өдөр

ТӨВ, ОРОН НУТГИЙН ОНЦГОЙ БАЙДЛЫН БАЙГУУЛЛАГЫН ГАЛ ТҮЙМЭР УНТРААХ, АВРАХ АНГИУДАД ЗОХИОН БАЙГУУЛАХ “ӨВӨЛЖИЛТИЙН БЭЛТГЭЛ АЖЛЫГ ХАНГУУЛАХ, АЛБА ХААГЧДЫН АМЬСГАЛЫН БИЕ ДААСАН ТӨХӨӨРӨМЖТЭЙ АЖИЛЛАХ БЭЛЭН БАЙДЛЫГ ДЭЭШЛҮҮЛЭХ” НЭГДСЭН АРГА ХЭМЖЭЭНИЙ УДИРДАМЖ

### Нэг. Зорилго

Онцгой байдлын ерөнхий газраас 2020 онд дэвшүүлсэн зорилт, Гал түймэртэй тэмцэх газрын 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний 2.2.2-т заасныг хэрэгжүүлэх, төв, орон нутгийн Онцгой байдлын байгууллагын Гал түймэр унтраах, аврах ангиудын өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангуулах, алба хаагчдын амьсгалын бие даасан төхөөрөмжтэй ажиллах бэлтгэл, бэлэн байдлыг дээшлүүлэхэд чиглэгдэнэ.

### Хоёр. Нэгдсэн арга хэмжээг зохион байгуулах хугацаа, хамрах хүрээ

“Өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангуулах, алба хаагчдын амьсгалын бие даасан төхөөрөмжтэй ажиллах бэлэн байдлыг дээшлүүлэх” нэгдсэн арга хэмжээг 2020 оны 8 дугаар сарын 31-ний өдрөөс 2019 оны 10 дугаар сарын 05-ны өдрүүдийн хооронд Төв, орон нутгийн Онцгой байдлын байгууллагын газар, хэлтсийн харьяа Гал түймэр унтраах, аврах ангиуд зохион байгуулна.

### Гурав. Ажлын чиглэл

3.1. “Онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллагын тээврийн хэрэгсэлд техникийн үйлчилгээ, засвар хийх журам”-ын дагуу Гал түймэр унтраах тусгай тоноглол бүхий автомашин болон шуурхай албаны автомашин, техникийн ТҮУ (Техникийн улирлын үйлчилгээ)-г (ТҮ-I, ТҮ-II-ын хамт) хийж албаны бэлтгэл, бэлэн байдлыг дээшлүүлэх;

3.2. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дүрмийн хоёрдугаар бүлгийн 1, 2, 3 дахь хэсэгт заасны дагуу Гал түймэр унтраах, аврах ангийн ажлын байр, тавиулан, харуулын байрны агааржуулалт, гэрэлтүүлэг, дулаан, чийглэгийн түвшинг дүрэмд заасны дагуу сайжруулах ажлыг зохион байгуулах;

3.3. “Амьсгалын бие даасан төхөөрөмжтэй ажиллах үед дагаж мөрдөх дүрэм”-ийн Гуравдугаар бүлгийн нэгдүгээр хэсгийн 1.1-т заасны дагуу төхөөрөмж, бодис материалын нөөцийг бүрдүүлэн, төхөөрөмжүүдэд засвар, үйлчилгээг хийж бэлэн байдлыг хангах;

3.4. Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2020 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн А/99 дугаартай тушаалаар баталсан Онцгой байдлын байгууллагын “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөлийн ажиллах журам”-ын дагуу байгуулагдсан зөвлөл болон салбар зөвлөлийн ажлыг эрчимжүүлэн, хийсэн ажлын танилцуулгыг тайланд тусгах;

3.5. Объектын болон ой, хээрийн гал түймэр унтраах ажиллагаанд зориулсан хамгаалах тусгай хувцас, гал түймрээс хамгаалах хүн нэг бүрийн хэрэгслүүдийн судалгааг 1 дүгээр хавсралтад заасны дагуу гаргах;

3.6. Гал түймэртэй тэмцэх газраас боловсруулан Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2020 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн А/83 дугаар тушаалаар батлуулсан “Объектын гал түймэр унтраах ажиллагаанд зориулсан хамгаалах тусгай хувцас. Ерөнхий шаардлага” CS 11-0439:2020, “Ой, хээрийн гал түймэр унтраах ажиллагаанд зориулсан хамгаалах тусгай хувцас. Ерөнхий шаардлага” CS 11-0440:2020, “Гал түймрээс хамгаалах хүн нэг бүрийн хэрэгсэл. Ерөнхий шаардлага” CS 11-0441:2020 байгууллагын стандартууд, мөн 2020 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн А/96 дугаар тушаалаар

батлуулсан “Объектын болон ой, хээрийн гал түймэр унтраах ажиллагаанд зориулсан хамгаалах тусгай хувцас, хүн нэг бүрийн хамгаалах хэрэгслийг хэрэглэх журам”-ыг алба хаагчдад танилцуулж, мэдээлэл хийх (стандарт, журмыг Онцгой байдлын ерөнхий газрын [www.nema.gov.mn](http://www.nema.gov.mn) сайтын хууль, эрх зүй хэсэгт байршуулсан).

#### Дөрөв. Тавигдах шаардлага

Удирдамжит нэгдсэн арга хэмжээний тайлан нь дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

1. Нөөцөд бүрдүүлсэн цэвэрлэгээ, ариутгал, тослогоо, үл цантуулах зориулалттай тусгай бодис, материал тус бүрийн нэршил, хэмжээний талаар тэмдэглэгээ хийж тусгай зориулалтын хайрцагт байрлуулсан байх.

2. Амьсгалын бие даасан төхөөрөмж, сэлбэг хэрэгсэл хадгалах болон агаар хадгалах сав цэнэглэх өрөө, тасалгааны зургийг ирүүлэх.

3. Нэгдсэн арга хэмжээний гүйцэтгэлийн тайланг удирдамжийн ажлын чиглэлийн заалт тус бүрээр тодорхой гаргаж, удирдах албан тушаалтнаар баталгаажуулсан байх.

4. Объектын болон ой, хээрийн гал түймрийн хөдөлмөр хамгааллын хувцас, хамгаалах хэрэгслүүдийн судалгааг удирдах албан тушаалтнаар баталгаажуулсан байх.

5. Удирдамжийг хэрэгжүүлэхтэй холбоотой ажлуудыг зохион байгуулах үед коронавируст халдвараас урьдчилан сэргийлэх зөвлөмжүүдийг мөрдөн ажиллах.

*Жич: Хийгдсэн ажлуудыг гэрэл зургаар баталгаажуулж, тайланд хавсаргасан байна.*

#### Тав. Мэдээ, тайлан ирүүлэх

Нэгдсэн удирдамжит арга хэмжээний хүрээнд зохион байгуулсан ажлын тайланг 2020 оны 10 дугаар сарын 1-ний өдрийн дотор цахим хэлбэрээр Онцгой байдлын ерөнхий газрын Гал түймэртэй тэмцэх газрын Гал унтраах хэлтсийн (Skype-[OBEG Gal tuimertei temtseh gazar](#)) хаягаар, албан бичгээр 2020 оны 10 дугаар сарын 5-ны өдрийн дотор тус тус ирүүлсэн байна.

#### Зургаа. Нэгдсэн удирдамжийг дүгнэх

1. Нэгдсэн удирдамжит арга хэмжээний хүрээнд хийгдсэн ажлын тайланг хүлээн авч, нэгтгэн дүгнэж Онцгой байдлын ерөнхий газрын дэд даргад танилцуулна.

2. Удирдамжийн хүрээнд санаачлагатай, үр бүтээлтэй ажиллаж алба хаагчдын аюулгүй байдал, эрүүл ахуйг бодитой дээшлүүлсэн хамт олныг урамшуулах, хангалтгүй зохион байгуулсан удирдах албан тушаалтанд холбогдох дүрэм, журамд заасны дагуу хариуцлага тооцно.

ОНЦГОЙ БАЙДЛЫН ЕРӨНХИЙ ГАЗАР

..... ГАЗАР (ХЭЛТЭС)-ЫН ГАЛ ТҮЙМЭР УНТРААХ, АВРАХ .... ДУГААР АНГИЙН ОБЪЕКТЫН БОЛОН ОЙ, ХЭЭРИЙН ГАЛ ТҮЙМЭР УНТРААХ АЖИЛЛАГААНД ЗОРИУЛСАН ХАМГААЛАХ ТУСГАЙ ХУВЦАС БОЛОН ГАЛ ТҮЙМРЭЭС ХҮН НЭГ БҮРИЙГ ХАМГААЛАХ ХЭРЭГСЛИЙН СУДАЛГАА

Огноо

№	Гал түймэр унтраах, аврах анги	Хамгаалах тусгай хувцас				Хүн нэг бүрийн хамгаалах хэрэгсэл (тоо ширхэг)						
		Объектын		Ой, хээрийн		Хамгаалалтын малгай /дуулга/	Дуулган дотуур өмсөх малгай	Бүс	Карбин	Байлдааны сүх	Бээлий	Гутал
		Нийт тоо ширхэг (хуваарьт болон нөөцөд байгаа)	Шаардлагатай тоо ширхэг	Нийт тоо ширхэг (хуваарьт болон нөөцөд байгаа)	Шаардлагатай тоо ширхэг							
1												
2												
3												
4												
Санал хүсэлт		Хувцасны чанар, үзэмж, эдлгээ гэх мэт				Хэрэгслүүдийн чанар, эдлгээ гэх мэт						

СУДАЛГАА ГАРГАСАН: .....

ХЯНАСАН: .....